

**ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН
2025**

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**





ГАРЧИГ

БИД ХЭН БЭ?	2-5
КАМПАНИТ АЖИЛ	6-31
ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХИЙН ТӨЛӨӨ	7
ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ, ЭРСДЭЛД БУЙ	
ХУВЬ ХҮМҮҮСИЙН ТӨЛӨӨ	14
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ СОЁЛЫН ЭРХИЙН ТӨЛӨӨ	18
ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ БҮХ НИЙТЭД	27
БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ	32-36
САНХҮҮГИЙН ТАЙЛАН	37
2025 ОНД ХЭВЛЭСЭН НОМ ТОВХИМОЛ	38

БИД ХЭН БЭ?

Нобелийн шагналт олон улсын хүний эрхийн Эмнести Интернэшнл нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад баримт бичгүүдэд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрд адил тэгш эдлүүлэхийн төлөө үйл ажиллагаа өрнүүлдэг дэлхийн томоохон хөдөлгөөн бөгөөд Монгол Улсад 1994 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид ажилладаг бөгөөд улс төрийн нам, засгийн газраас санхүүжилт авдаггүй.

Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 8000 гаруй гишүүд, дэмжигчидтэй, нийслэл болон орон нутгийн хэмжээнд мэргэжил, болоод сонирхлын 15 гаруй бүлэг, сайн дурын ажилтнууд, кампанит ажлын багуудтайгаар ажиллаж байна.

ГИШҮҮД, ДЭМЖИГЧИД, ХАМТРАГЧИД



8676

гишүүн,
дэмжигч



150+

хамтрагч
байгууллага

Залуучууд **73%**

Мэргэжил, сонирхлын бүлэг

16%


Орон нутаг

11%


БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА



ДЭЛХИЙ ДАХИНД



МОНГОЛ УЛСАД



2025 ОНЫ ҮР НӨЛӨӨ (ТООГООР)



Эрхийнхээ төлөө бичигцгээе аяны
хүрээнд эрсдэлд буй хүмүүсийн төлөө

13,000+
захидал


илгээлээ.



Хүний эрхийн төлөө

340+


үйл ажиллагаа, нөлөөллийн
уулзалт, сургалтыг хийлээ.



2025 онд давхардсан тоогоор

25,453 идэвхтэн

үйл ажиллагаанд нэгджээ.



2025 онд давхардсан тоогоор

911,692 хүн

үйл ажиллагаанд нэгджээ.



УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Б.Мөнхжавхлан

Удирдах зөвлөлийн дарга



М.Батбаатар

Удирдах зөвлөлийн дэд дарга



А.Отгончимэг

Санхүү хариуцсан гишүүн




Б.Баялагмаа

Кампанит ажил хариуцсан гишүүн



Б.Хүслэн

Кампанит ажил хариуцсан гишүүн



Б.Бадрал

Сан арвижуулалт хариуцсан гишүүн



М.Нандинцэцэг

Гишүүнчлэл хариуцсан гишүүн



Д.Оюунномин

Хүний эрхийн боловсрол хариуцсан гишүүн



Г.Хүрэлчулуун

Залуучууд хариуцсан гишүүн

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ



С.Нажидмаа

Хяналтын зөвлөлийн дарга



З.Үүрийнтуяа

Хяналтын зөвлөлийн гишүүн



Б.Очирбат

Хяналтын зөвлөлийн гишүүн

ГҮЙЦЭТГЭХ ТОВЧОО



Б.Алтантуяа

Гүйцэтгэх захирал



Г.Амарзаяа

Кампанит ажлын Зохицуулагч



Я.Цэцэнзаяа

Кампанит ажлын Зохицуулагч



У.Наранцацрал

Санхүүгийн ажилтан



Г.Сүхбат

Өсөлт, хөгжил хариуцсан Зохицуулагч



Б. Тэргэл

ХЭБ, сан арвижуулалт хариуцсан Зохицуулагч 7 сар хүртэл



Б.Аззаяа

Касс, ложистик хариуцсан ажилтан



Б.Оюунбат

Гэрээт ажилтан



И.Балжинням

Судлаач



Э.Энхтайван

ХЭБ, сан арвижуулалт хариуцсан Зохицуулагч 9 сараас хойш



ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ БА ИРГЭНИЙ ОРОН ЗАЙ

ЗОРИЛТ

КАМПАНИТ АЖИЛ

- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан бодлого, хууль тогтоомжийг халуулах, цаашид ийм төрлийн зохицуулалт шинээр бий болохоос сэргийлэхэд хувь нэмрээ оруулах
- Иргэний нийгмийн орон зайг бэхжүүлж, хүний эрхийг хамгаалах үйлсэд залуучуудын оролцоо, дуу хоолойг нэмэгдүүлэх





ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ

ЭРХ ЧӨЛӨӨГ БЭХЖҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ

Монголын Эмнести Интернэшнл нь үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг бэхжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, бодлогыг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмжийг холбогдох талуудад хүргүүлж, хүний эрх хамгаалагч, сэтгүүлч, МЭИ-ийн гишүүд, дэмжигчдийн мэдлэг чадавхыг нэмэгдүүлсэн хүний эрхийн боловсрол олгосон үйл ажиллагаануудыг зохион байгууллаа.

Мөн дэлхий дахинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлснийхээ төлөө эрх нь зөрчигдсөн, эрсдэлд буй хувь хүн, бүлэг хүмүүсийн эрхийг хамгаалахыг уриалсан цахим уриалга, эв санааны нэгдлээ илэрхийлсэн уулзалт, арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.



Монголын Эмнести Интернэшнлээс 2025 онд Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний төлөөх Үндэсний сүлжээ, Иргэний нийгмийн консерциум, Хүний эрхийн ТББ-ын Форум болон, хуульч, судлаач, хүний эрхийн хамгаалагчидтай хамтран ажиллаж, иргэний нийгмийн орон зайг хамгаалах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг түгээн дэлгэрүүлэх, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэх асуудлаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулав.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТӨЛӨӨХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

2025 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн асуудлаар

12

удаагийн уулзалт, хэлэлцүүлэг

400+

иргэний нийгэм, сэтгүүлч, хуульч, иргэдийн төлөөлөл

давхардсан тоогоор хамрагджээ.

“Уг хуулийн төсөл нь төрийн оролцоог хязгаарлаагүй, эх сурвалжаа нууцлах эрхийг хэлбэрийн төдий тодорхойлж, сэтгүүл зүйн үйл ажиллагааны баталгааг хангаагүй, Эрүүгийн болон бусад хуультай уялдаагүй, хожим цензур тогтооход ашиглагдах эрсдэлтэй нэр томъёо, тодорхойлолт, заалтыг тусгасан байна.”

10 сарын 14, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн нэр томъёо” хэлэлцүүлэгт оролцсон хуульчийн үг

Хэлэлцүүлэгт оролцсон сэтгүүлчид хуулийн төсөл нь нэр томъёоны түвшинд тодорхойгүй, мэргэжлийн үйл ажиллагаа гэж заасан нь иргэний сэтгүүл зүйн орон зайг хумих эрсдэлтэй, “ташаа”, “илт худал мэдээлэл” гэх ойлголтууд нь сэтгүүлчийг хамгаалах бус, шүүхэд татах үндэслэл болох магадлалтайг дурдлаа.



QR КОДЫГ УНШУУЛЖ,
ЦАХИМ ХУУДСААР ЗОЧЛООРОЙ

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД

АМИКУС ТОЙМ БЭЛТГЭН ХҮРГҮҮЛЭВ.

Эмнести Интернэшнл нь олон улсын хүний эрхийн асуудлууд, тухайлбал эрх чөлөөтэй байх, халдашгүй байх эрх болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, уг эрхэд зүй бусаар хөндлөнгөөс нөлөөлөх явдлаас хамгаалах төрийн үүрэг зэрэг олон улсын эрх зүйн чухал асуудлыг шийдвэрлэхэд туслах зорилгоор олон улсын болон бүс нутгийн шүүхэд хандан amicus curiae тойм болон бусад гуравдагч этгээдийн тайлбар, мэдээлэл хүргүүлж байсан арвин туршлагатай. Энэ хүрээнд 2025 онд Үндсэн Хуулийн Цэцийн хүсэлтийн дагуу Амикус тоймууд бэлтгэн хүргүүлээ.

ДУР ЗОРГООР ЦАГДАН ХОРИХЫГ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭГЭЭР ЗОГСООХ ҮНДЭСЛЭЛ

3 дугаар сард бэлтгэн гаргасан Амикус тоймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 14.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэгт заасан цагдан хорих зохицуулалтын талаарх олон улсын хэм хэмжээг багтаалаа.

Тус амикус тоймд “Хүн бүр хувийн эрх чөлөө, халдашгүй байх эрхтэй бөгөөд энэ нь бусад этгээдээс дур зоргоор баривчлах, цагдан хорихоос хамгаалдаг. Уг эрхийг ИУТЭОУП-ын 9(1) дэх заалтаар баталгаажуулсан бөгөөд олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцоор өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн.

Эрх чөлөөг дур зоргоор хассан эсхүл олон улсын эрх зүй, хэм хэмжээнд нийцээгүй хэргийг мөрдөн шалгах тусгай чиг үүрэг бүхий НҮБ-ын Дур зоргоор баривчлан саатуулах асуудлаарх ажлын хэсгийн баталгаажуулснаар дур зоргоор цагдан хорихыг хориглох нь олон улсын эрх зүйн заавал дагаж мөрдөх хэм хэмжээ бөгөөд цагдан хорих нь эрүүдэн шүүх болон бусад хэрцгий байдлаар харьцуулахаас ангид байх эрх, шударгаар шүүлгэх эрх зөрчигдөх эхлэл цэг болдог тул дээрх эрхийг хамгаалах нь чухал” болохыг онцлон дурдсан.



ҮГ ХЭЛЭХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАСАН ЗААЛТ ҮНДСЭН ХУУЛЬ ЗӨРЧСӨНД ТООЦОГДОВ.

Үндсэн хуулийн цэцийн хүсэлтийн дагуу 8 дугаар сард Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн зохицуулалтын талаар бэлтгэн хүргүүлсэн Амикус тоймд хүн бүр үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд энэ эрхийг улсын хил хязгаарыг үл харгалзан бүх төрлийн мэдээлэл, үзэл санааг хайх, хүлээн авах, түгээх эрхийг агуулсан ИУТЭОУП-ын 19 дүгээр зүйлээр баталгаажуулсныг онцолж, 19 дүгээр зүйлийн 2-т заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь бөгөөд зөвхөн ИУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлд заасан журмын дагуу хязгаарлагддаг болохыг дэлгэрэнгүй тусгасан.

Үндсэн хуулийн цэцээс 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр гаргасан 10 дугаар дүгнэлтэд “Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж, уг заалтыг 2025 оны арваннэгдүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж шийдвэрлэсэн.





МОНГОЛ УЛС: МЯНГЫГ АЙЛГАХЫН ТУЛД НЭГИЙГ СОНГОН ЯЛЛАЖ, ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХИЙГ ХӨСӨРДҮҮЛЖ БАЙНА

Монгол Улс нь шударгаар шүүлгэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлаж, хүний эрхийн ноцтой ухралт гаргаж байгаад Монголын Эмнести Интернэшнл санаа зовниж байгаагаа илэрхийлж **“Монгол Улс: Мянгыг айлгахын тулд нэгийг сонгон яллаж, шударгаар шүүлгэх эрхийг хөсөрдүүлж байна”** хэвлэлийн мэдээг гаргалаа.

Монгол Улсын Засгийн газар, түүний бодлого, үйл ажиллагаа, албан тушаалтныг шүүмжилсэн олны танил, сөрөг хүчний гишүүн, сэтгүүлч, хүний эрх хамгаалагч болон бусад хувь хүмүүсийг онилон мөрдөн шалгах, ял оноох, бусад байдлаар дур зоргоор эрх чөлөөг нь хязгаарлах явдал гарсаар байгаа бөгөөд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар иргэний орон зай, эдийн засаг, нийгмийн эрхийг хязгаарлан урьд өмнө гаргасан хүний эрхийн ахиц дэвшлээ үгүйсгэж байна.

03 сарын 20, Монголын Эмнести Интернэшнлийн Хэвлэлийн мэдээ

Мөн шүүхийн шийдвэр гараагүй байхад төрийн өндөр албан тушаалтнууд мөрдөн шалгагдаж байгаа хүмүүсийг гэм буруутай мэтээр хэвлэл мэдээллээр зарлах нь гэм буруугүйн ойлголтыг зөрчиж, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг дордуулж байгааг дурдаж, цаашид Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар баталгаажсан дур зоргоор баривчлагдахаас ангид байх, шударгаар шүүлгэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тайван хуран цуглах, чөлөөтэй зорчих эрхийг дур зоргоор, хэтрүүлэн хязгаарлахаа зогсоохыг эрх баригчдаас шаардлаа.



QR КОДЫГ УНШУУЛЖ,
ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭТЭЙ
ТАНИЛЦАНА УУ.



Цогц хөгжлийн Үндэсний төвөөс зохион байгуулсан Монгол Улсын аюулгүй байдал, иргэний нийгмийн хөгжил, түүхэн нөхцөл, өнөөгийн сорилт, ирээдүйн төлөвийг нийтийн эрх ашгийн хүрээнд авч үзэн олон нийт, бодлого боловсруулагчид, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор хамтын ойлголтод хүрэх зорилготой хэлэлцүүлгийг дэмжин ажиллалаа.



ЖАГСАХ ЭРХИЙГ ХАМГААЛ

КАМПАНИТ АЖИЛ

ЗОРИЛТ

- *Бүх нийтийн тайван цуглах эрхийг баталгаажуулах*



БҮХ НИЙТИЙН ТАЙВАН ЦУГЛАХ ЭРХИЙГ

БАТАЛГААЖУУЛАХЫН ТӨЛӨӨ

Монгол Улс нь тайван хуран цуглах эрхийг ялгаварлан гадуурхахгүйгээр хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэгтэй. Үүнд төрийн эрх бүхий байгууллагууд хуран цуглах үйл ажиллагаанд үндэслэлгүйгээр хөндлөнгөөс оролцохгүй байх, жагсагчдыг бусад этгээдийн зүгээс гарч болзошгүй саад, халдлагаас хамгаалах бүхий л арга хэмжээг авах, хуран цуглах эрхээ бодитоор хэрэгжүүлэх боломжийг нь бүрдүүлэх үүрэг багтана.

Засгийн газраас 1 дүгээр сард УИХ-д өргөн барьсан “Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл” нь тайван хуран цуглах эрхийн талаарх олон улсын хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг нягталж шалгах хуудсыг боловсруулан УИХ-ын 126 гишүүнд хүргүүлж, хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэхийг уриаллаа.

ЖАГСАГЧДЫГ
ХАМГААЛ

ЦУВРАЛ 1

Тайван замаар хуран цуглах эрх чөлөөний талаарх мэдлэг ойлголтыг түгээх видео, подкаст, постер, гарын авлага боловсруулан гаргаж, гишүүд, дэмжигчид, олон нийтэд цахим сүлжээгээр хүргэлээ. Эрүүдэн шүүхээс хохирсон хүмүүст туслах олон улсын өдрөөр хууль сахиулах ажиллагаанд хэрэглэгдэж байгаа зэвсэг, хэрэгслийн худалдаанд дэлхий дахины хяналт бий болгохыг зорьж буй Эрүүдэн шүүхээс ангид Худалдааны Гэрээ батлахыг НҮБ-ын гишүүн улс орнуудаас шаардах даян дэлхийн уриалгад гишүүд, дэмжигчид нэгдлээ.

Жагсаал цуглааны үеэр үйл явдлыг баримтжуулж, тэмдэглэл хөтлөх зэргээр ажиглалт хийх нь хүний эрхийн өөрчлөлтөд хүрэх чухал хэрэгсэл болдог. Ажиглалтын үр дүнд жагсаал цуглаан тайван өрнөсөн эсэх, жагсаал цуглааны хязгаарлалт нь дур зоргын эсвэл ялгаварлан гадуурхах зорилготой байсан эсэх, зайлшгүй, тохирсон эсэхийг тогтоох баримт мэдээлэл цуглуулж, хүний эрх зөрчигдсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэхэд тусалдаг. Монголын Эмнести Интернэшнлээс аливаа жагсаал цуглааны үеэр хүний эрхийн ажиглалт, мониторинг хэрхэн хийх тухай сургалтыг 2022 оноос эхлэн хүний эрх хамгаалагч, иргэний нийгмийн идэвхтнүүдэд явуулж ирсэн. 2025 онд “Жагсаал цуглаан ба хүний эрхийн ажиглагч” сургалтад ХЭҮК-ын шинэ ажилтнууд, МЭИ-ийн идэвхтэн, орон нутгийн бүлгийн гишүүд тус тус хамрагдаж, жагсаал цуглааны үеэр хүний эрхийн ажиглалт, мониторинг хийх чадавхид суралцлаа.



2025 оны 1 болон 5 дугаар сард өрнөсөн “Засгийн газар огцор”, “Огцрох амархан” жагсаал цуглааны үеэр хийсэн ажиглалт, мониторингоор цагдаагийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход шаардагдах бэлэн байдал дутмагаас жагсагчдын биед халдсан үйлдлийг таслан зогсоох, хамгаалах арга хэмжээ аваагүй, жагсагчдыг ялгаварлан гадуурхах хандлага байгааг тогтоолоо. Иймд Монгол Улс нь нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Үндсэн хуулиар баталгаажсан тайван жагсаал цуглаан хийх эрхийг хамгаалах үүргээ биелүүлээгүйд Монголын Эмнести Интернэшнл санаа зовниж байгаагаа илэрхийлж, жагсаал, цуглааны үеэр үйлдэгдэж буй хүчирхийлэлд тохирох арга хэмжээг авч, жагсагчдад халдсан тухайн үйлдлийг нэн даруй мөрдөн шалгаж, буруутай этгээдэд зохих хариуцлага тооцохыг шаардлаа.





Технологи ба хүний эрх сэдвийн хүрээнд технологийн хүний эрхэд үзүүлж буй нөлөөлөл, хүний хувийн мэдээлэл хамгааллын асуудлаар багш, оюутнуудын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр ШУТИС-тай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Энэ хүрээнд ШУТИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн их сургуулийн багш нар “Инженерийн ёс зүй” хичээлийг судалж буй оюутнуудын бие даалтын ажлын хүрээнд төрийн өмч бүхий байгууллага, хувийн хэвшлийн харьяалалд буй камерууд нь хүний хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж буй эсэх, хүний эрхийн зөрчил үүсэх нөхцлийг бүрдүүлж буй эсэхийг тандахаар Улаанбаатар хотын Эрх чөлөөний талбай орчмын камеруудыг судаллаа.



Ирээдүйн инженерүүдийг стандарт, хүний эрх, ёс зүй, хууль эрх зүйн мэдлэгтэй болоход хувь нэмэр оруулах зорилготой энэхүү үйл ажиллагаа нь оюутнуудын технологитой холбоотой хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, цахим орчин дах хүний эрхийн зөрчил, мэдээллийн аюулгүй байдал, өөрийн эрхийг хэрхэн хамгаалах, бусдын эрхийг зөрчихгүй байхад анхаарах зэргээр онол, практикийг хослуулсан үнэ цэнтэй дадлага ажил байлаа. Уг дадлага ажлын үр дүнд хяналтын камер нь гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх зорилготой ч хууль эрх зүйн хамгаалалт дутмаг, сул тохиолдолд зөвшөөрөлгүй, хууль бусаар хүний хувийн мэдээлэлд халдах, хүний эрхийг зөрчих эрсдэлтэйг харууллаа. Судалгаагаар зарим орон сууцны орцны камерууд хүний халдашгүй байх эрхийг зөрчих эрсдэлтэй, камерын бичлэг хийж байгааг анхааруулсан тэмдэглэгээ байхгүй, дүрс бичлэгийг буруугаар ашиглаж хүний эмзэг мэдээллийг олон нийтийн сүлжээнд зөвшөөрөлгүй түгээж байгаа зэрэг зөрчлүүд илэрлээ.

2025 оны 11 дүгээр сарын 4-нд НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэг(ЭДХ)-ээр Монгол Улсын хүний эрхийн нөхцөл байдлыг хэлэлцэхтэй холбогдуулан Эмнести Интернэшнлээс зөвлөмж гаргалаа.

Үүнд: Монгол Улсаас Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр-II-ийг баталж, Ази, Номхон далайн бүсийн Хүний эрхийн боловсрол, сургалтын төв байгуулах амлалтаа хэрэгжүүлэхийг уриаллаа. Мөн ОУЭШ-тэй хамтран ажиллах үүргээ биелүүлэх, технологи ашиглан үйлдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох чиглэлээр хууль эрх зүйн болон бодлогын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, мэдээлэл хуваалцаж, түгээснийх нь төлөө Эрүүгийн хуулиар шийтгэхгүй байх, эрүүдэн шүүх гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан механизм байгуулах зэргээр халдашгүй байх, тайван хуран цуглах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үр дүнтэй баталгаажуулахыг шаардлаа.



Эмнести Интернэшнлийн санаачилгаар Хүний эрхийн Үндэсний Комисс, МУИС-ийн Улс төр судлал, олон улсын харилцаа нийтийн удирдлагын сургуулиуд хамтран “Олон улсын гэрээний санаачилгууд ба Монгол улсын оролцоо» сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 9 дүгээр сард зохион байгууллаа. Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн Академи, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, Хууль зүйн үндэсний хүрээлэн зэрэг байгууллагын төлөөлөл, их, дээд сургуулийн багш, судлаачид оролцсон тус хэлэлцүүлгээр дэлхий дахинд хууль сахиулах үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа эрүүдэн шүүх хэрэгслийн худалдааг хориглох тухай Эрүүдэн шүүхээс ангид худалдааны гэрээ болон Хүн төрөлхтний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц батлахын ач холбогдлын талаарх ойлголт мэдээллийг өгч, оролцогчдыг олон улсын эрх зүйн асуудлаарх яриа хэлэлцүүлэгт идэвхтэй оролцохыг уриаллаа.

НҮБ-ЫН ХҮН ТӨРӨЛХТНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧДИЙГ ШИЙТГЭХ ТУХАЙ КОНВЕНЦ

Хүн төрөлхтний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон хохирогчдыг нөхөн сэргээх, бодит үнэн, шударга ёсыг тогтоох шинэ боломжуудыг санал болгож буй энэ конвенц батлагдвал бүх улс эдгээр гэмт хэргийг үндэсний эрх зүйн тогтолцоондоо тусгах, эрүүгийн хариуцлагад татагдсан сэжигтнүүдийг бусад улстай хамтран шүүх боломжийг олгох цогц тогтолцоог бүрдүүлэх юм.

НҮБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХЭЭС АНГИД ХУДАЛДААНЫ ГЭРЭЭ

Монгол Улс нь НҮБ-аар батлуулахаар зорьж буй Эрүүдэн шүүхээс ангид худалдааны гэрээ (Torture-Free Trade Treaty)-г санаачилагч улс орнуудын нэг бөгөөд тус гэрээ нь:

(1) уг чанараараа хүчирхийллийн, эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцахаас өөр зориулалтаар ашиглагддаггүй хууль сахиулах хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа, холбогдох үйл ажиллагааг хориглох;

(2) эрүүдэн шүүх, зүй бус харьцаад ашиглагдаж болзошгүй хэрэгслийн худалдаанд хүний эрхэд суурилсан үр нөлөөтэй хяналтын тогтолцоог бий болгох зорилготой юм. Энэхүү санаачилга нь хүний эрхийг хамгаалах олон улсын эрх зүйн чухал алхам болно.



ЭРСДЭЛД БУЙ ХУВЬ ХҮН, ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ НЬ

КАМПАНИТ АЖИЛ

ЗОРИЛТ

- Хүний эрх хамгаалагчийг таниулан хамгаалах, хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг шаардах.
- Эрсдэлд буй хувь хүн, хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэх.





ДЭЛХИЙ ДАХИНЫ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2025 ОНЫ 4 ДҮГЭЭР САР- ТАЙЛАНГИЙН НЭЭЛТ

Монголын Эмнести Интернэшнлээс МУИС-ийн Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуультай хамтран 4-р сарын 29-нд зохион байгуулсан Дэлхийн хүний эрхийн төлөв байдал тайлан танилцуулах хэлэлцүүлэгт төрийн болон ТББ байгууллагын төлөөлөл, ХЭҮК, эрдэмтэн, судлаачид, хуульчид, их сургуулийн багш, оюутнууд, МЭИ-ийн гишүүд дэмжигчид оролцлоо.

Эмнести Интернэшнлийн тайланд дэлхий дахинд дарангуйллын бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагаа хурдацтай тархаж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, иргэний орон зай хумигдаж, төрлөөр устгах гэмт хэрэг үйлдэгдсэнийг онцоллоо. Ялгаварлан гадуурхах бодлого, үйл ажиллагаа цагаачид, дүрвэгсэд, харьяалалгүй хүмүүс, арьс үндсээр ялгаварлан гадуурхагдсан бүлгүүдэд илүүтэй сөргөөр тусч, улс орнууд нийгмийн хамгааллыг хангах, түүнд хяналт хэрэгжүүлэхдээ автоматжуулсан төхөөрөмж хэрэглэж байгаа нь ялгаварлан гадуурхалтыг өдөөж, шударга бус байдлыг дэвэргэж байгааг тусгасан байна.



Ази номхон далайн бүс нутгийн тойм:

Улс төрийн үймээн самуун, дарангуйлал, зэвсэгт мөргөлдөөн зэрэг нь Ази номхон далайн бүс нутагт санаа зовоосон хүний эрхийн дүр зургийг бий болголоо. Гэхдээ хүний эрх хамгаалагчид, идэвхтнүүд асар их эрсдэлийг үл тоон эрхээ шаардаж, дарангуйллын эсрэг дуугарсаар байна. Шинээр батлагдсан хууль, дүрмүүд нь хүний эрх, ялангуяа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг улам бүр хязгаарлаж, жагсаал цуглааныг хууль бусаар хүч хэрэглэн тарааж, улмаар хүний амь насыг хохироосон үйл явдлууд ч гарлаа.

Бүс нутгийн тайланд Монгол Улсад эрх баригчид нийслэл Улаанбаатар хотод 2000 орчим өрхийг амьдран суугаа газраас нь албадан нүүлгэсэн, Ромын дүрмийн оролцогч тал болох Монгол Улс ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путиныг 2024 оны есдүгээр сард тус улсад айлчлах үеэр дайны гэмт хэрэг үйлдсэн хэргээр баривчлах тухай ОУЭШ-ийн шийдвэрийг биелүүлээгүй, уул уурхайн үйл ажиллагаа малчдын амьдрал, амьжиргаанд сөргөөр нөлөөлж байгаад санаа зовниж байгаагаа НҮБ-ын уугуул хүмүүсийн эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч илэрхийлснийг тус тус онцолжээ.




QR КОДЫГ УНШУУЛЖ,
ДЭЛХИЙН ТАЙЛАНТАЙ
ТАНИЛЦАНА УУ.

“ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ НИЙГМИЙН АЖИЛТАН”-УУДЫГ ОНЦОЛЛОО.



Монголын Эмнести Интернэшнлээс Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Цогц Хөгжлийн Үндэсний төвтэй хамтран 11 сарын 29 буюу Эмэгтэй хүний эрх хамгаалагчдын олон улсын өдрийг тохиолдуулан “Хүний эрх хамгаалагч нийгмийн ажилтан” форум зохион байгууллаа. 21 аймаг, нийслэл хотын нийт 150 гаруй хамгааллын нийгмийн ажилтнууд, 50 гаруй төрийн холбогдох албан тушаалтан, эрдэмтэн судлаачид, оюутнууд оролцсон тус арга хэмжээний үеэр хүний эрх хамгаалагчийн тухай, нийгмийн ажилтны хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа, их дээд сургуульд нийгмийн ажилтан бэлтгэх хөтөлбөрүүдийн хүний эрхийн агуулга, нийгмийн ажилтныг дэмжих төрийн үүргийн талаар хэлэлцэж, цаашид холбогдох байгууллагуудад санал зөвлөмж хүргүүлэхэд анхаарал хандуулахаар болов.

Нийгмийн ажил үйлчилгээ нь хүний эрхэд суурилсан байх ёстой бөгөөд нийгмийн ажилтан нь эдийн засаг, нийгэм, соёлын эрх, мөн тэрчлэн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн эмзэг бүлгийн эрхийг хамгаалж, төрийн үйлчилгээ, халамжийн үйлчилгээнд холбох зэргээр тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэхэд нь мэргэжлийн аргаар тусалдаг.



ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЭ

2025 оны Эрхийнхээ төлөө бичицгээе аяны хүрээнд Эмнести Интернэшнлийн гишүүд дэмжигчид Засгийн газар болон компаниудын байгаль орчинд учруулж байгаа хор хөнөөлтэй үйл ажиллагааг зоригтой эсэргүүцснийхээ төлөө баривчлагдсан Камбожийн залуу тэмцэгчид, Кыргызстанд авлигын хэргийг илчилснийхээ төлөө хоригдсон Махабат, Мьянмар, Тунис улсад зөвхөн сэтгүүлчийн ажлаа хийснийхээ төлөө хоригдох ял авсан Сай Зо Тэйк, Соня Дахмани нарыг нэн даруй, ямар нэг болзолгүйгээр суллахыг шаардлаа.

2001 онд дэлхий даяар 2326 захидал илгээж байсан бол, 2024 оны байдлаар 200 гаруй улс орон, газар нутагт захидал бичих, твиттерээр жиргэх, өргөх бичигт гарын үсэг зурах болон хүний эрхийн төлөөх бусад үйл ажиллагаа 4.6 саяд хүрч өрнөсөн. Өмнөх жилүүдэд Эмнестигийн гишүүд, дэмжигчдийн илгээсэн захидал уриалгын үр дүнд улс орнуудад цаазаар авах ялыг цуцалж, эрүүдэн шүүх эрсдэлээс хамгаалж, дүрвэгч, цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалж, хилс хэргийг цагаатгаж, хүний эрх зөрчигчдөд хариуцлага тооцсон өөрчлөлтүүд гарлаа.

Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан дэлхийн 150 орчим улс, газар нутагт Эрхийнхээ төлөө бичицгээе аян өрнөж, Эмнести Интернэшнлийн гишүүд дэмжигчид Засгийн газар болон компаниудын байгаль орчинд учруулж байгаа хор хөнөөлтэй үйл ажиллагааг зоригтой эсэргүүцснийхээ төлөө баривчлагдсан Камбожийн залуу тэмцэгчид, Кыргызстанд авлигын хэргийг илчилснийхээ төлөө хоригдсон Махабат, Мьянмар, Тунис улсад зөвхөн сэтгүүлчийн ажлаа хийснийхээ төлөө хоригдох ял авсан Сай Зо Тэйк, Соня Дахмани нарыг нэн даруй, ямар нэг болзолгүйгээр суллахыг шаардлаа. Мөн ган гачгийн улмаас шилжин суурьшсан Дамисоа болон бусад хүмүүст тулгараад буй өлсгөлөн, эрүүл мэндийн үйлчилгээ дутмаг байдлыг шийдвэрлэх яаралтай алхам авч хэрэгжүүлэхийг Мадагаскарын засгийн газраас шаардах, Гондурасын хойд нутгийн ой мод, гол мөрөн, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнг уул уурхайн болон эрчим хүчний төслүүдийн аюул заналхийллээс хамгаалахаар уйгагүй тэмцэж ирсэн Хуан Лопесын амь насаа алдсан хэргийг үр дүнтэй мөрдөн шалгах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэгч Амазоны дайчдын аюулгүй байдлыг хамгаалах, Норвегийн хойд нутгийн цаа буга малладаг эртний нүүдэлчин амьдралын өв соёлыг хадгалж үлдэх, уугуул иргэдийн эрхийг хамгаалахыг уриалсан захидал уриалгыг илгээлээ.



9 кейс дээр
13000+
захидал





ЭДИЙН ЗАСАГ НИЙГЭМ СОЁЛЫН ЭРХИЙН ТӨЛӨӨ

КАМПАНИТ АЖИЛ

ЗОРИЛТ

- Алагчлалгүй, тэгш байдлыг дээдлэх соёл, хандлагыг хүний эрхийн боловсролоор дамжуулан түгээж, жендэрт суурилсан хүчирхийлэл, тэгш бус байдлыг бууруулахад хувь нэмэр оруулах.
- Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон нийт, тэр дундаа нөлөөлөлд буй иргэд, төрийн ойлголтыг нэмэгдүүлэх.





Дэлхийн хүн амд 65 ба түүнээс дээш насны ахмадууд 2022 онд 10 хувийг эзэлж байсан бол 2050 онд 16 хувь болж өснө. Ази, Номхон далайн бүсийн зарим улсуудад насжилт нэмэгдэж, хүн ам зүйн өөрчлөлт эрчимтэй явагдаж байна. Бүс нутгийн хэмжээнд 2050 он гэхэд 60-аас дээш насны иргэдийн тоо 2 дахин нэмэгдэж, 1.3 тэрбумд хүрэхээр байна. Насжилт уртассанаар улс, үндэстнүүдийн онцлог, ялгаатай байдлаас үл хамааран нийгэм, эдийн засаг, соёл, хүн ам зүйн сорилтуудтай тулгарч байна. Ахмад настныг халамж хүртэгч, нийгмийн идэвхгүй гишүүн мэтээр харах өрөөсгөл ойлголт давамгайлж байгаагаас үүдэн ялгаварлан гадуурхалтаас ангид байх, нийгмийн амьдралд тэгш оролцох, нийгмийн баялгаас тэгш хүртэх зэрэг хүний эрх зөрчигдөх явдал дэлхий нийтэд түгээмэл байна.

Гэвч олон улсын хүний эрхийн баталгаа нь ахмадуудаас хол, тэдний онцлогт тохироогүй, эрхийг бүрэн хамгаалж чадахгүй байна. Иймд Иргэний нийгэм, хүний эрхийн байгууллага болон олон улсын байгууллагуудын зүгээс ахмадын эрхийн чиглэлээр бие даасан Конвенц батлахыг олон жил шаардаж ирсэн. Үүний үр дүнд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс ахмад настны хүний эрхийн талаарх Конвенц боловсруулах асуудлыг 2025 оны 58 дугаар чуулганаараа авч хэлэлцэн “Ахмад настны хүний эрхийн талаарх олон улсын заавал дагаж мөрдөх хэм хэмжээ бүхий баримт бичгийг боловсруулах, Хүний эрхийн зөвлөлд өргөн барих мандат бүхий Засгийн газар хоорондын нээлттэй ажлын хэсэг” байгуулахаар шийдвэрлэсэн.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн энэхүү санаачилгыг дэмжиж **“Идэвхтэй насжилт: Ахмадад ээлтэй нийгмийг бүтээх нь” Ази, Номхон далайн бүсийн форумыг** Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монголын Эмнести Интернэшнл хамтран 2025 оны 06 дугаар сарын 19, 20-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгууллаа.

Энэхүү форумаар:

- Олон жил яригдсан Ахмад настны эрхийн тухай НҮБ-ын Конвенцыг батлуулах үйл явцын хүрсэн үр дүнг урагшлуулах;
- Бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх
- Насжилтаас үүдэн тулгамдаж буй асуудал, боломж, шийдлийг хэлэлцэн ахмадын настны эрхийн хамгааллыг бэхжүүлэх, санал санаачилгуудыг дэмжихэд чиглэсэн **“Улаанбаатарын уриалга”**-ыг баталсан юм.



АХМАДЫН ЭРХИЙН ТӨЛӨӨХ

ИРГЭНИЙ НИЙГМИЙН МАНЛАЙЛАЛ

Ази, Номхон далайн бүс нутгийн форумыг угтан иргэний нийгмийн байгууллагуудын урьдчилсан хэлэлцүүлгийг Монголын Эмнести Интернэшнл, Хүний эрх хөгжил төв, Монголын Хүний эрхийн форум, МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ хамтран Монголын Эмэгтэйчүүдийн сан, Ахмад настны эрхийн төлөөх дэлхийн холбоо (GAROP)-ны дэмжлэгтэйгээр зохион байгуулав.

Уулзалтад Австралийн холбооны улс, Бүгд найрамдах Солонгос улс болон Монгол улсын иргэний нийгмийн байгууллагууд, Ахмадын байгууллага, их, дээд сургуулийн профессор, багш нар болон Ахмадад ээлтэй хөтөлбөр хэрэгжүүлдэг хувийн хэвшлийн төлөөлөл оролцлоо. Зөвлөлдөх уулзалтаар ахмад настны эрхийг хамгаалах олон улсын конвенцын төслийг дэмжин батлуулахад Монголын Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг зураглан ирээдүйн хэлэлцээрт үр дүнтэй оролцох мэдлэг, туршлагаа хуваалцаж, цаашдын алхмыг тодорхойлжээ.



Ахмад настны эрхийн конвенцын төслийг боловсруулах Засгийн газар хоорондын ажлын хэсэгт Монгол Улсын Засгийн газар идэвхтэй хамтран ажиллахаа онцлов.

Олон улсын ахмадын өдрийг угтан “Ахмад настны эрхийн талаарх амлалтаа бэхжүүлье” талуудын дугуй ширээний уулзалтыг төр, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн хамт зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр Ази, Номхон далайн бүсийн форумын үр дүн болох “Улаанбаатарын уриалга”-ыг хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллахын чухлыг тодотгохын зэрэгцээ Ахмад настны эрхийн конвенцын төслийг боловсруулах Засгийн газар хоорондын ажлын хэсэгт “Монгол Улсын Засгийн газар идэвхтэй хамтран ажиллахыг уриаллаа.” Түүнчлэн оролцогч талууд ахмад настны эдийн засгийн хараат бус байдал, тэтгэвэр, тэтгэмж, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, асаргаа, сувилгааны хүртээмж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүчирхийллээс ангид байх эрх зэрэг асуудлыг хөндсөн бөгөөд төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулан, хамтын ажиллагааг өргөжүүлэх нь ахмад настны эрхийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай гэдгийг онцлон тэмдэглэлээ.



УУР АМЬСГАЛЫН ШУДАРГА ЁСЫГ ШААРДАХ НЬ

Сүүлийн 80 жилийн хугацаанд Монгол орны агаарын дундаж температур 2.46°C-аар нэмэгдэж байгаагаас харахад Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөж буй улс орны нэг юм. Уур амьсгалын өөрчлөлт нь газрын доройтол, усны хомсдол, зудын давтамж болон цар хүрээг нэмэгдүүлэн хурцатгаж байна. Түүнчлэн, агаарын температурын өсөлт нь эдийн засгийн гол салбар болох хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт ихээхэн хохирол учруулж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл, цаг уурын эрс тэс үзэгдэл зуд, ган, хэт халалт зэрэг нь малчдын амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, нүүдэлчин аж ахуй соёлд шууд сөрөг нөлөө дагавартай. Түүнчлэн уул уурхайн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн тэлэлт нь малчдын бэлчээрийг хуваах, багасгах, бэлчээрийг доройтуулах, уул уурхайн нөлөөллөөс үүссэн олон салаа зам, түүнээс үүдсэн тоосжилт болон цэвэр усны хомсдол зэрэг нь хүн, малын амь нас, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Монголын Эмнести Интернэшнл нь уур амьсгалын өөрчлөлтийн хамгийн эмзэг нөлөөлөлд өртөж буй малчдын эрхийн асуудлаар судалгаа хийн уул уурхайн говийн бүсийн нөлөөлөлд өртөж буй иргэдтэй уулзаж баримтжуулах ажлыг эхлүүлээ.

Түүнчлэн Уур амьсгалын шударга ёсны асуудлаар азлуучууд тэр дундаа нөлөөлөлд өртсөн малчид, нутгийн иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор "УС-АМЬ-ЭРХ" зуны сургалт зохион байгууллаа. Сургалтад оролцогчид өөрсдийн аж амьдрал, мал ахуйд нөлөөлж буй уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг танин мэдэх, баримтжуулах, бусаддаа хуваалцах, уур амьсгалын өөрчлөлтийн хүний эрхийн нөлөөллийг үнэлэх чадварт суралцлаа.





ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙН ХУУЛИЙН ХАМГААЛАЛТЫГ ШААРДАЦГААЯ

КАМПАНИТ АЖИЛ

ЗОРИЛТ

- *Орон байртай байх, эрүүл байх эрх, нийгмийн халамж, татвар, төсвийн хэмнэлттэй холбоотой бодлогыг хүний эрхэд ээлтэй болгоход иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эрхийн хэрэгжилтийг сайжруулах.*





Монгол Улсад 2000 онд нийт хүн амын 57 хувь нь хот суурин газарт амьдарч байсан бол 2022 онд 69 хувь хүртэл өссөн нь Зүүн Азийн бүсийн дундаж түвшнээс давсан үзүүлэлт юм.[1] Хот суурин газар тэлэн хөгжихийн хэрээр хотыг дахин төлөвлөх, хөгжүүлэх бодлого, хөтөлбөрүүд улам бүр олширсоор байна. Монгол Улсад хот төлөвлөлтийн бодлого, эрх зүйн ерөнхий орчин бүрдсэн хэдий ч хүний эрхийн хандлага, олон улсын хүний эрхийн эрх зүйн хэм хэмжээ, олон улсын сайн туршлагад нийцүүлэх, бодлого зохицуулалтыг уялдуулах, хэрэгжилтийг үр дүнтэй хангах, тогтмол мониторинг, дүн шинжилгээ хийх, хүний эрхийн үүргийг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгох асуудал чухлаар хөндөгдөж байна.

[1] Дэлхийн Банк, Бодлогын төлөвлөгөө, алхам: Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтод чиглэсэн бодлогын голлох зөвлөмжүүд, 2024 оны 7 сар, 56 дахь тал, дараах холбоосоос бүрэн эхээр нь үзнэ үү

<https://documents1.worldbank.org/curated/en/099081324043574533/pdf/P500438-a9b6d27a-7d59-4d7b-b5f7-baba68d01bdb.pdf> (хамгийн сүүлд үзсэн 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр).

Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хүндэтгэх, хамгаалах, тэр дундаа эзэмшлийн аюулгүй байдлыг хангах, нөлөөлөлд өртсөн иргэдтэй мэдээлэлтэйгээр зөвшилцөх, шударга нөхөх олговор олгох, эзэмшлийн аюулгүй байдалд халдах үндэслэл болон шударга процессын хэм хэмжээг хуулиар тодорхой, ойлгомжтой зохицуулах, хэрэгжилтэд үр дүнтэй хяналт хэрэгжүүлэх, хүний эрхэд үндэслэсэн маргаан шийдвэрлэх механизмын хүртээмжийг нэмэгдүүлэх асуудал тулгамдсан хэвээр байна.

Хот суурин газрыг дахин хөгжүүлэх, төлөвлөх төсөл хөтөлбөрийн нөлөөлөлд өртсөн иргэдийн эрх ашгийг хамгаалах, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн олон улсын пактаар хамгаалагдсан шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн хамгаалалтыг Монгол улсын хууль тогтоомжид тусган нийцүүлэх зорилгоор Монголын Эмнести Интернэшнл байгууллага 2016 оноос хойш ажиллаж байна.



ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЯВЦАД ХЭНИЙ Ч ЭРХ ЗӨРЧИГДӨХГҮЙ БАЙХ ХУУЛИЙН ХАМГААЛАЛТ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн нөлөөлөлд өртсөн иргэд эрхээ хамгаалуулахаар гомдол гаргах хуулийн хамгаалалт, механизм байхгүйн дээр, иргэний өмчийн газрыг Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр, шүүхийн үр дүнтэй хяналтгүйгээр, цагдаагийн байгууллагын хүч дэмжлэгээр албадан чөлөөлөх практик хэрэгжиж байгаа нь Нийслэлийн засаг дарга цагдаагийн албаны хүчийг дур зоргоор ашиглах нөхцөлийг бүрдүүлж, зөрчигдсэн эрхийг шүүхээр хамгаалуулах эрх, шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх Үндсэн хуулийн заалтыг ноцтой зөрчиж байна.

Тиймээс Монголын Эмнести Интернэшнлийн хуульчдын бүлгийн гишүүн, өмгөөлөгч, хуульчид нөлөөлөлд өртсөн иргэдтэй уулзах, мэдээлэл хуваалцах, баримтжуулах, холбогдох шийдвэр гаргагч нарт тойм, мэдээлэл хүргүүлэх зэргээр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудалд анхаарал хандуулан ажиллаж байна.

Түүнчлэн Монголын Эмнести Интернэшнл санаачлан, Хүний эрхийн Форумын гишүүн байгууллага болон Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороотой хамтран хот төлөвлөлтийн нөлөөлөлд өртсөн иргэдтэй уулзах, нөхцөл байдалтай нь танилцаж мэдээлэл хуваалцах “Хотын Автобустай Аялал” нөлөөллийн уулзалт зохион байгуулж, Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороо хот дахин төлөвлөлтийн хүний эрхийн үр нөлөөг хэлэлцэх дараагийн шатны хэлэлцүүлэг зохион байгуулах үүрэг, амлалт өглөө.



ЭРХ ЗҮЙН ХӨТЧӨӨС ҮЙЛДЭЛД ЧИГЛЭСЭН НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ РУУ

Монголын Эмнести Интернэшнл, Монгол Улсын Их Сургууль, Шихихутуг Их Сургууль, Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн Клиник сургалтын төвтэй хамтран шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн “Оюутан хөтөч нар”-ыг бэлтгэн СБД-ийн 14-р хороо, ЧД-ийн 14, 18-р хороо буюу Сэлбэ дэд төв болон Сонгинохайрхан дүүргийн Баянхошуу дэд төвийн нөлөөлөлд өртсөн хорооны оршин суугч, иргэдтэй уулзаж, зөвлөгөө мэдээлэл түгээх, цахим орчинд мэдээлэл түгээх зэргээр ажиллав. Тэд хот дахин төлөвлөлтийн нөлөөлөлд өртсөн иргэдийн дуу хоолойг нэгтгэх, тулгамдаж буй асуудлыг холбогдох байгууллагад хүргэх бодлогын нөлөөллийг дэмжин ажиллаж байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн нөлөөлөлд өртсөн иргэд хангалттай хугацаанд, мэдээлэлтэйгээр, бодитоор зөвлөлдөх боломж нөхцлөөр хангагдаагүйгээс үүдэн хөрөнгийн үнэлгээний тайлантай бүрэн танилцах, бүрэн хүлээж авахгүйгээр гэрээ хэлэлцээрт орох, амьжиргааг нь дордуулан үнэлсэн үнэлгээний дүгнэлтийг шууд болон шууд бусаар хүлээн зөвшөөрөхөөс өөр сонголтгүй болох, гэрээ хэлэлцээрт ороогүй байхад нь өмчийн эрхэд халдан барилгын ажил эхлүүлсэн зэрэг хүний эрхийн ноцтой зөрчлийн талаарх мэдээллийг эрх зүйн хөтөч нар баримтжууллаа.



ХҮНДЭЭ ЭЭЛТЭЙ ХОТЫН ТӨЛӨӨ

НҮБ-аас 2016 оны 10 дугаар сард зохион байгуулсан “Орон байр, Тогтвортой хотын хөгжил” олон улсын хурлаас баталсан “Хотжилтын шинэ хөтөлбөр” (New Urban Agenda)-г улс орнууд өнөө болон ирээдүйн үеийнхэн ялгаварлан гадуурхалтгүйгээр үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломж бүрдүүлсэн, хүний эрхийг хүндэтгэсэн хотод амьдрах боломжийг баталгаажуулахын тулд нэн тэргүүнд:

- Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралынхаа нөхцөлөө байнга сайжруулах эрхийн бүрэлдэхүүн болох шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх,
- Бүхий л оршин суугчдын хэрэгцээг хангах, эмзэг нөхцөлд байгаа хүмүүсийн онцгой хэрэгцээг хүлээн зөвшөөрөх замаар олон талт нийгмийн гишүүдийн уялдаа холбоо, оролцоо, аюулгүй байдлыг хангахыг[1] чухалчилсан.

Гэвч сүүлийн 20 орчим жилийн хугацаанд хот суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд өргөн хүрээнд хэрэгжүүлсэн хэдий ч төлөвлөлтийн үйл ажиллагаанд барилгажилтад илүүтэй анхаарч ядуурал, тэгш бус байдлыг бууруулах, иргэдийн амьдралын нөхцөл, амьжиргааны чанар, эх үүсвэрийг сайжруулах нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг нэмэгдүүлэх зэрэг чиглэлд бодитой ахиц гарсангүй.

[1] United Nations, New Urban Agenda (2017) available at <https://habitat3.org/the-new-urban-agenda> (accessed 07 December 2025)


Нийгмийн өргөн хүрээнд айл өрхийн амьжиргаа, нийгэм, эдийн засгийн эрхэд сөргөөр нөлөөлөх аливаа төсөл, хөтөлбөрт нийгмийн, байгаль орчны болон хүний эрхийн нөлөөллийн үнэлгээг хийх, мэдээллийн ил тод байдлыг хангах тогтолцоо аль ч салбарт бүрэн бүрдээгүй нь судалгаанд суурилсан, хүний эрхийн хэм хэмжээ, зарчимд үндэслэсэн бодлого, эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагаа хэрэгжүүлэх нөхцөлийг алдагдуулж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагддаг “ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ ФОРУМ”-аар “Хүндээ ээлтэй хот”-ын үзэл баримтлалыг ч мөн дээрх агуулгаар томъёолов. Тус форумыг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Эмнести Интернэшнл хамтран зохион байгуулж, Монголын Эмнести Интернэшнлийн хуульчдын бүлгийн гишүүн Р.Очирбал илтгэл хэлэлцүүллээ.





ЭЭЛТЭЙ ХОТ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ЗОРИЛГОД СЭТГҮҮЛЧИД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛЛАА.



НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын 11-р зорилго болох Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих зорилго нь хот, хүн амын суурьшлыг бүх талын оролцоог хангасан, аюулгүй, эрсдлийг даван туулах чадвартай, тогтвортой болгох үзэл санааг агуулдаг. Ээлтэй хот гэдэг нь иргэдийн оролцоог хангасан, хамтын оролцоотой, нэгдсэн төлөвлөлттэй, бүх нийтэд хүртээмжтэй, тогтвортой хөгжилтэй хотыг хэлнэ.

Хот төлөвлөлтийн бүхий л үе шатанд олон нийтийг тэр дундаа нөлөөлөлд өртсөн иргэдийг идэвхтэй, утга учиртайгаар оролцуулах, мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээллийн бүхий л эх үүсвэрийг ашиглан тэнцвэртэй, бодит мэдээллийг олон нийтэд түгээх, шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц санал, санаачилгыг дэмжих зорилгоор Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монголын Эмнести Интернэшнл болон "Тогтвортой Хөгжлийн Төлөө" сэтгүүлчдийн клуб хамтран "Хүний эрх ба хүндээ ээлтэй хот" сэтгүүл зүйн сайн бүтээлийн уралдааныг гурав дахь жилдээ зохион байгуулж дүгнэлээ.

Уралдаанд 20 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын болон чөлөөт 35 сэтгүүлч оролцож, 51 сурвалжилга, нийтлэл ирүүлжээ. Энэ жилийн уралдаан нь тогтвортой хөгжлийн "Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих" зорилтын хэрэгжилтэд хувь нэмэр оруулах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн бодит нөхцөл байдлыг олон нийтэд ойлгуулах, тулгамдсан асуудлыг тодруулах, олон улсын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэв.

Тэргүүн байр

- Vpress.mn сайтын сэтгүүлч Г.А. Батзаяа "Нэг л асуулт: Албадан чөлөөлөх нь шийдэл мөн үү?"
- "Зууны мэдээ" сонины сэтгүүлч Ц.А. Мягмарбаяр "Дахин төлөвлөлтийн хохирогчид Сэлбэ дэд төвөөр үргэлжилсээр..."

Дэд байр

- ТВ8 телевизийн сэтгүүлч Б. Хонгорзул
- "Дахин төлөвлөлт ингэж үргэлжилбэл өмчтэй иргэн үлдэхгүй нь"
- "Өнөөдөр" сонины тоймч О. Бат-Ундрах
- "Угаарын урхаг буюу хотжилтын шинэ өвчин"

Гуравдугаар байр

- МҮОНРТ "Монголын мэдээ" сувгийн сэтгүүлч Э. Отгонцэцэг
- "Харааны бэрхшээлтэй иргэдийн эрхийг хүртээмжгүй дэд бүтцээр зөрчсөөр..."
- Vpress.mn сайтын сэтгүүлч Б.А. Бодхүү
- "Ээлтэй хотын шийдэл: Тэдэнд зориулаад барьчихвал бүгдэд хүртээмжтэй болно"

Тусгай байр

- iToim.mn сайтын сэтгүүлч Г. Хэрлэн, Х.А. Бямбажаргал
 - "Хотын стандартыг нүхэн жорлонгийн хувьсгалаас эхлүүлье"
 - Child.mn сайтын сэтгүүлч А. Уянгаа
- "Хүндээ ээлгүй хотын золиос – хүүхэд" сурвалжилга

Уралдааны шаардлагад нийцэхүйц бодит кейс, тодорхой асуудал, сайн туршлагыг хөөн сурвалжилсан, асуудал дэвшүүлсэн, сэдэл санаа өгсөн, гарц шийдлийг эрэлхийлсэн бичвэрүүд байгааг олзуурхуштай гэж үзлээ. Нөгөө талд, сэтгүүл зүй, ялангуяа хөгжлийн сэтгүүл зүйн чиглэлээр нийтэлж, нэвтрүүлдэг сэтгүүлчид бүтээлч үйл ажиллагаа, ур чадвараа ахиулах, сайжруулахад анхаарах шаардлага байна

Сайн бүтээлийн уралдааны гурван хараат бус шүүгчийн нэг, МУБИС-ийн НХУСАА-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор (Ph.D) Ч. Энхбатын санал, зөвлөмж



ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ БҮХ НИЙТЭД

КАМПАНИТ АЖИЛ

ЗОРИЛТ

- *Алагчлалгүй, тэгш байдлыг дээдлэх соёл, хандлагыг хүний эрхийн боловсролоор дамжуулан түгээж, жендэрт суурилсан хүчирхийлэл, тэгш бус байдлыг бууруулахад хувь нэмэр оруулах.*



ХҮНИЙ ЭРХЭД ЭЭЛТЭЙ СУРГУУЛЬ

Дэлхий ертөнцийн өнөөгийн нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлт, ядуурал, хүйсийн болон нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэйгээр боловсролыг хувирган өөрчлөх замаар дэлхий нийтээрээ тогтвортой хөгжил бүхий шударга ирээдүйг бий болгох шаардлага үүсэж байна. Улс орнууд эрхэд суурилсан боловсролын орчин, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх замаар суралцагчдын сурах эрх бүрэн хангагдана гэдгийг хүлээн зөвшөөрч, "Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь"- Боловсролын нийгмийн шинэ гэрээг боловсролын талаарх алсын хараа болгон тодорхойлж байна. Энэхүү алсын харааг бодит үйл хэрэг болгох, үл алагчлах байдал, хүний эрх, энх тайван байдлыг бэхжүүлэхэд боловсролын гүйцэтгэх үүрэг улам бүр чухал болж байна.

НҮБ-ын Хүний Эрхийн Боловсролын Дэлхийн Хөтөлбөрийн зорилтын хүрээнд Эмнести Интернэшнл байгууллагаас 2009 оноос "Хүний Эрхэд Ээлтэй Сургууль" хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж ирсэн. Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөр нь сургуулийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хүүхдийн эрх, хөгжил хамгааллын бодлогод хүний эрхийн үнэт зүйлс суурь зарчмуудыг тусган хэрэгжүүлж, ерөнхий боловсролын байгууллагуудад хүний эрхийн хандлага соёлыг төлөвшүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг.



Хүний эрхийн үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлж, сургуулийн удирдлага, багш эцэг эх, сурагчдын тэгш оролцоог хангах замаар сургуулийн бүхий л орчин дахь хүний эрхийн зөрчлийг арилгаж, хүний эрхийг дээдэлсэн, харилцан бие биеэ хүндэлдэг орчныг бүрдүүлэх зорилготой тус хөтөлбөрт Нийслэл Улаанбаатар болон Дархан, Эрдэнэт хот, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын 32 сургууль нэгдсэн байна. ХЭЭС хөтөлбөр нь 2024-2026 онд Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймгийн 14 сургуульд хэрэгжих болно.



“УЛСЫН ЭРХ- 111” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Нийтийн эрх ашгийн сан, Монголын Эмнести Интернэшнл, Цогц хөгжлийн үндэсний төв, Отгонтэнгэр их сургууль, Шихихутуг их сургууль, Монгол Улсын Их Сургууль, Чимэд сан хамтран Улсын эрх” бүтээлийн 111 жилийн ойг тохиолдуулан “Улсын эрх-111” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа.

Монгол Улсын анхны Ерөнхий сайд Т.Намнансүрэнгийн зарлигаар 1914 онд Ж.Цэвээний туурвисан уг бүтээл нь тухайн үед өндөр хөгжсөн улсуудын үндсэн хууль, төрийн байгуулал хийгээд нийгмийн зохион байгуулалтыг харьцуулан судалж улсын хөгжлийн замыг тодорхойлсноороо улс төр, эрх зүйн сэтгэлгээний сонгодог бүтээлд тооцогддог.

Хоёр дахь жилдээ зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурлын онцлог нь оюутан болон ахисан түвшний судлаач гэсэн ангилалд зохион байгуулагдлаа. Шалгарсан илтгэлүүдийг хэлэлцүүлэг байдлаар гурван салбар хуралдаан байдлаар олон нийтэд танилцууллаа.



“ЭРХЭЭ МЭДЬЕ” КАРЛ ПОППЕРЫН МЭТГЭЛЦЭЭНИЙ ТЭМЦЭЭН

Хүний эрхийн боловсрол түгээн дэлгэрүүлэх зорилготой “Эрхээ мэдье” анхлан мэтгэлцэгчдийн аварга шалгаруулах тэмцээнийг Монголын Карл Попперын Мэтгэлцээний нийгэмлэгтэй хамтран 10 дугаар сарын 17-оос 10 дугаар сарын 19-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Тэмцээнд нийслэлийн 67 баг, орон нутгийн 61 баг оролцож нийтдээ 384 сурагч хүний эрхийн боловсролын мэдлэгээ дээшлүүлж, мэтгэлцэх ур чадвараа дээшлүүлээ.





ФИЛОСОФИЙН ОЛИМПИАД: “ХИЙМЭЛ ОЮУН УХААН БА ЁС ЗҮЙ”

Монголын Эмнести Интернэшнл, МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим, ШУТИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн сургууль хамтран жил бүр зохион байгуулдаг “Философи-Хүний эрхийн уулзварт” олимпиад энэ жил “хиймэл оюун ухаан ба ёс зүй” сэдвийн хүрээнд зохион байгуулагдлаа.

Олимпиадад 17 их сургуулийн 150 орчим оюутан хиймэл оюун ухааны хөгжил, ашиглалттай холбоотой эрсдэл, үр дагаврын талаар философи-ёс зүйн онолын үүднээс задлан шинжилж, хүний эрхийн үүднээс шүүмжлэлт сэтгэлгээгээр хандан оролцоо.

НӨХӨРСӨГ ЖААЛУУД СУРГАЛТ

Үе тэнгийн шоглох, дээрэлхэх, дарамтлахын эсрэг сургалтад “Хобби” болон “Канад” сургуулийн дунд болон ахлах ангийн нийт 211 сурагч хамрагдлаа.



ЭМНЕСТИ ПОДКАСТ

Эмнести Интернэшнлийн судалгаа, хүний эрхийн кампанит ажлын талаар мэдлэг, ойлголт түгээх, хүний эрхийн боловсрол олгох зорилготой “Amnesty Podcast”-аар дэлхий дахинаа тулгамдаж буй хүний эрхийн асуудлууд, жагсаал цуглаан ба хүний эрх, Олон улсын эрх зүй зэрэг сэдвээр судлаач, мэргэжилтнүүдтэй ярилцлаа.



ЯРЬДАГ ФУТБОЛК: ДАРАНГУЙЛЛЫГ БҮҮ ХҮЛЦЭН ТЭВЧ

“Ярьдаг Футболк 2025” өдөрлөг “Дарангуйллыг бүү хүлцэн тэвч” уриан дор 5 дугаар сарын 31-нд Рио Паркын Задгай Ногоон талбайд 800 орчим иргэний нийгмийн байгууллага, хүний эрх хамгаалагч, идэвхтэн тэмцэгч, Хүний эрхэд ээлтэй сургуулийн төлөөлөл оролцож, өөрсдийн урласан футболкоор дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийллээ.

Өдөрлөгийн хүрээнд футболкны уралдаан, урлагийн тоглолт, хүний эрхийн өртөөнүүд, нээлттэй микрофон, парад алхалт зохион байгуулагдаж, хүний эрхийг урам зориг, эв нэгдэлтэйгээр мэдрэх орон зай бүрдэв.

Энэ жилийн “Ярьдаг Футболк 2025” өдөрлөг нь Улаанбаатар хотоос гадна Архангай, Баян-Өлгий, Дархан-Уул, Завхан, Орхон, Ховд аймгуудад зохион байгуулагдаж, цахимаар өрнүүлсэн футболкны өдрийн активизм 150,000 гаруй хүнд хүрснээрээ онцлогтой байв.





БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ

ЗОРИЛТ

- Өөрсдийн нөөц бололцоо, оролцоог хамгийн дээд түвшинд хүргэх.





“ХҮНИЙ ЭРХ, ХҮМҮҮНЛЭГ ДЭЛХИЙН ТӨЛӨӨ” ХХІІІ ЕРӨНХИЙ ЧУУЛГАН

Монголын Эмнести Интернэшнл (МЭИ)-ийн “Хүний эрх, хүмүүнлэг дэлхийн төлөө” ХХІІІ Ерөнхий чуулган 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Үндэсний номын сангийн шинэ байранд амжилттай болж өндөрлөлөө.

Чуулганд Монгол Улсын өнцөг булан бүрээс ирсэн орон нутгийн төлөөлөгчид, мэргэжил, сонирхлын бүлгүүд, залуучууд, хамтрагчдын төлөөлөл зэрэг олон талт төлөөлөл оролцож, МЭИ-ийн 2023–2025 оны үйл ажиллагаа, тайлан, стратегийн чиглэл, ирэх хоёр жилийн бодлого, зорилтоо хэлэлцлээ.

Хүндэт зочид, олон улсын түншүүдийн мэндчилгээ Канадын Эмнести Интернэшнл, Малайзын Эмнести Интернэшнлээс эв санааны нэгдлээ илэрхийлж мэндчилгээ дэвшүүлсэн бол. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс болон нийгэм, улс төр, урлагийн салбарын зүтгэлтнүүд хүндэтгэлийн үг хэлж, чуулганд оролцогчдод амжилт хүслээ.



Өнөөдөр бидэнд дарангуй засаглал, талцал, худал хуурмаг, хүчирхийллийн эсрэг үнэт зүйлээ хамгаалан бат зогсох чухал цаг үе тохиогоод байна. Хүний эрхийн төлөөх ажил хэзээ ч шулуун дардан байгаагүй, дуусдаггүй, дундардаггүй, зогсдоггүй. Ухрах, цөхрөх цаг бидэнд байхгүй. Хэн нэгнийг хүлээх бус бид өөрсдөө жижиг ч атугай үйлдлээр том өөрчлөлтийг бүтээх ёстой. Харанхуйд лаа асаах шиг итгэл найдвар, хүмүүнлэг чанарыг түгээх цаг.

МЭИ-ийн Гүйцэтгэх захирал Б.Алтантуяагийн Ерөнхий чуулганы нээлтийн үеэр хэлсэн үг.

Чуулганаар “МЭИ-ийн 2023-2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн тайлантай танилцсан бол “Илүү үр нөлөөтэй хөдөлгөөн болохын төлөө Хүний эрхийн төлөө хөрөнгө оруулъя, Хүний эрхийн төлөө оролцоогоо өнгөлье, Засаглалаа бэхжүүлье” сэдвээ хэлэлцүүлэг өрнүүллээ. Мөн Удирдах зөвлөлийн гишүүний сонгууль, Хяналтын зөвлөлийн сонгууль болж, шинээр МЭИ-ийн Удирдах зөвлөлийн даргаар Б.Мөнхжавхлан, дэд даргаар М.Батбаатар, санхүүчээр А.Отгончимэг, гишүүнээр Г.Хүрэлчулуун нар Хяналтын зөвлөлийн даргаар С.Нажидмаа, гишүүнээр З.Үүрийнтуяа, Б.Очирбат нар тус тус сонгогдлоо.



ГИШҮҮД БОЛОН ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

Бид 2025 онд хүний эрхийг ойлгодог, дэмждэг хувь нэмрээ оруулдаг, хандив өргөдөг хүмүүсээр хүрээгээ тэлж, илүү олон талт, оролцоотой, илүү олон идэвхтэн, дэмжигчдийг дайчилсан байгууллага боллоо.

Гишүүдийн өрнүүлсэн, оролцсон активизм:

- Хүний эрх, хүмүүнлэг дэлхийн төлөө
- Let the Children Live хүүхдийн эрхийн асуудлаар
- Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийн өдөр
- Иргэний нийгмийн өдөр
- Японы цаазаар авах ялын эсрэг активизм
- Малайзын цаазаар авах ялын эсрэг активизм
- Эрүүдэн шүүхээс ангид худалдааны гэрээг батлахыг шаардах
- Арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг таслан зогсоох ОУ-ын өдрийн цахим активизм
- Эх хэлээ хэрэглэх эрхийн талаар эх хэлний дэлхийн өдрийн активизм
- Монголын Ахмадын эрхийн активизм
- Орон байртай байх эрхийн цахим активизм
- АНУ-ын Хэн ч хуулиас дээгүүр биш активизм
- Төсөв ба хүний эрх активизм
- Английн жагсагчдыг хамгаал
- Тайландын жагсагчдыг хамгаал
- Колумбийн жагсагчдыг хамгаалах
- CEASE FIRE NOW активизм
- Технологи ба хүний эрх
- Камбожийн активизм
- Зэвсэг нийлүүлэхээ зогсоо активизм
- Дүрвэгсдийн эрхийн олон улсын өдрийн активизм
- Эль Сальвадорын хүний эрх хамгаалагчийг хамгаал
- Монголын Хүний эрх хамгаалагчийг хамгаал

Удирдлага, манлайлал, байгууллагын чадавх

Удирдах Зөвлөл /УЗ/ нийт 7 удаа хуралдаж, 23 шийдвэр гаргаснаас 22 шийдвэр буюу 96%-ийн биелэлттэй байна. 1 шийдвэр нь хэрэгжих шатандаа байна. Хяналтын Зөвлөл /ХЗ/ байгууллагын үйл ажиллагаа болон санхүү дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт тавьж ажилласан байна. УЗ, ХЗ-д зориулсан сургалтад идэвхтэй хамрагдахаас гадна, Эрсдлийн үнэлгээ хийж, эрсдлийг үнэлэх, Дэлхийн болон бүс нутгийн чуулганаар хэлэлцэх асуудлууд, бодлогын хэлэлцүүлгүүдийг УЗ-ийн гишүүд манлайлан ажиллалаа.

Ажилтнууд, манлайлагч гишүүд, залуучууд чадавхи бэхжүүлэх сургалтуудад идэвхтэй хамрагдлаа. Тухайлбал; Эрсдэл, цахим аюулгүй байдлын сургалт, Бүс нутгийн сан арвижуулалтын, Бүс нутгийн кампанит ажлын зохицуулагч нарын, Олон улсын болон бүсийн төвөөс зохион байгуулсан Активизмын сургалт, Жагсаал, цуглааны ажиглагч бэлтгэх сургалт, гэх мэт 15 гаруй төрлийн сургалтад хамрагдаж чадавхи нэмэгдүүлээ.





ОРОН НУТГИЙН БҮЛГҮҮД

Орон нутгийн бүлгүүд бие даан үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэв.

Тухайлбал; Архангай, Баян-Өлгий, Завхан, Дархан-Уул, Орхон, Ховд зэрэг 7 аймагт Ярьдаг футболк өдөрлөг, "Hello Amnesty & Write for Rights" аян тус бүр зохион байгуулагдаж, 22.000 гаруй хүнд хүний эрхийн боловсрол олгож, 5.000 гаруй захидал илгээж, хүрээгээ тэлжээ.

Мөн орон нутгийн бүлгүүд цахим болон цахим бусаар бодлогын хэлэлцүүлэг, Ерөнхий чуулган, Жагсаал цуглаан ажиглагчийн сургалт, аймагтаа бүх гишүүдийн уулзалт зэргийг зохион байгуулж, идэвхтэй дуу хоолойгоо илэрхийлдэг болов.

Ховд, Баян-Өлгий аймгуудад Арьс, үндсээр алагчлахын эсрэг сургалт, манлайллын сургалт, кино хэлэлцүүлэг зэргийг зохион байгуулж, Ховд аймагт Оюутны бүлэг шинээр үүсгэн байгуулагдлаа.



Байгууллагын сайн сайхан байдал (Wellbeing)

Монголын Эмнести Интернэшнл нь байгууллагынхаа сайн сайхан байдлыг дөрвөн тулгуур асуудал буюу аюулгүй байдал, ба амьдралын баталгаа, ажиллах орчин ба сэтгэл ханамж, ажлын зорилго ба утга учир, ажил дээрх сэтгэл зүйн болоод бие махбодийн эрүүл мэнд гэсэн өргөн хүрээтэйгээр авч үздэг. Дээрх 4 тулгуур үндсэн хүрээг хамарсан байгууллагын сайн сайхан байдлын тусгай төлөвлөгөөний дагуу бид хүний эрхийн идэвхтэн, гишүүд, ажилтнууд, УЗ, ХЗ-ийн гишүүд, манлайлагч гишүүд, хамтрагчдийн сайн сайхан байдлыг хангах чиглэлд анхаарч ажиллалаа.



САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Монголын Эмнести Интернэшнл

Санхүүжилт 2025		Санхүүжилт /ам.доллар/	
		Төсөвлөсөн	Гүйцэтгэл
Гишүүдийн татвар, хандивын тогтмол төлөлт		4,765.00	967.95
Тогтмол бус хандив		3,200.00	2,219.18
Тэтгэлэг олгогчийн санхүүжилт		56,700.00	40,675.49
Бусад сан арвижуулалт		65,175.00	11,271.26
Гишүүдийн татвар, сан арвижуулалт, хандивын тогтмол санхүүжилт		129,840.00	55,133.88
ОУТөвийн санхүүжилт		483,351.00	509,180.80
НИЙТ САНХҮҮЖИЛТ		613,191.00	564,314.68
Зарцуулалт 2025		Зарцуулалт /ам.доллар/	
		Төсөвлөсөн	Гүйцэтгэл
Хүний эрхийн стратегийн зорилт	Зорилго 1 - 2	415,732.10	256,256.85
Өөөлтийн стратегийн зорилт	Сан арвижуулах	39,617.95	29,226.85
	Бусад асуудал	29,099.40	24,182.52
Стратегийн зорилгоос гаднах хүний эрхийн үйл ажиллагаа		11,920.00	11,105.86
Удирдлага, дотоод ардчилал болон бусад дэмжих ажиллагааны зардал		116,821.55	114,063.16
Нийт зардал		613,191.00	434,835.23

Эхний үлдэгдэл			
	Бэлэн мөнгө (Касс болон банк)	75,221.01	
	Нөөцийн сан	153,429.59	
	Урьдчилж төлсөн төлбөр	4,181.80	
	Авлага	4,140.12	
	Өглөг	1,968.37	
Эцсийн үлдэгдэл			
	Бэлэн мөнгө (Касс болон банк)		124,994.81
	Нөөцийн сан		235,004.15
	Урьдчилж төлсөн төлбөр		1,088.62
	Авлага		4,485.61
	Өглөг		1,089.59

Тайлан хянасан:

Тайлан хянасан:

Тайланг бэлтгэсэн:




Б. Алтантуяа
Гүйцэтгэх захирал


А.Отгончимэг
Удирдах зөвлөлийн гишүүн, Санхүүч

У. Наранцацрал
Санхүүгийн ажилтан

2025 оны нийт санхүүжилт \$564315



2025 оны нийт зарцуулалт \$434835



БҮХ ЗҮЙЛ ТАНААС ЭХЭЛДЭГ

**ТАНЫ ТӨЛСӨН ТАТВАР,
ХАНДИВ, ХУДАЛДАН АВАЛТ
ДАРААХ ЗҮЙЛСЭД ЗАРЦУУЛАГДДАГ.**



ҮҮНИЙ ҮР ДҮНД БИД:



ХҮНИЙ ЭРХЭД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ ҮНЭХЭЭР АМАРХАН

Хүний эрхийн төлөө тэмцэнэ гэдэг нь та заавал гудамжинд уриа лоозон барьж жагсана гэсэн үг биш. Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааг дэмжиж гишүүн болох, өөрийн үнэт цаг, хөдөлмөрөөрөө хувь нэмэр оруулах, мөнгө хандивлах зэрэг нь дэлхий дахинд хүний эрх, шударга ёс авчрахын төлөө таны оруулж буй хувь нэмэр юм.

Та www.amnesty.mn цахим хуудсаар зочлон бидний хийж буй хүний эрхийн төлөө ажлуудтай танилцан доорх дансаар мөнгө хандивлаж болно.

Байгууллагын данс:

МN82 0005 0050 4129 2715

Дансны нэр: Монголын Эмнести Интернэшнл

Цахим хуудас руу орохыг хүсвэл доорхи QR-ийг уншуулна уу.



**2025 ОНЫ 700,000 ТӨРГӨГӨӨС ДЭЭШ
ХАНДИВ ӨГСӨН ХАНДИВЛАГДЧИД /МӨНГӨН,
МӨНГӨН БУС/:**

- Нээлттэй нийгэм форум ТББ
- Шихигхутуг их сургууль
- Отгонтэнгэр их сургууль
- Цогц хөгжлийн үндэсний төв
- Шинжлэх ухаан, технологийн их сургууль
- Монгол Улсын их сургууль
- Чимид сан

2025 ОНД ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ

